



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА СЭЛЭНГЭ АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАР

Сэлэнгэ аймгийн Аудитын газрын төлөвлөгөө,
удирдамжийн дагуу хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан

“ЦАГААННУУР ТОХИЖИЛТ ҮЙЛЧИЛГЭЭ” ОНӨААТҮГ-ЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН

*“Цагааннуур тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГ- нь орлогоо бүрэн төвлөрүүлж,
орлогоороо зарлагаа нөхөж, өөрөө өөрийгөө санхүүжүүлэн ажиллаж чадахгүй
байна.*

Сүхбаатар сум 2016 он

Тайланг бэлтгэсэн: ҮАГ-ын харьяа Сэлэнгэ аймгийн Аудитын газар	Товчилсон үгийн жагсаалт Аудитын хийх үндэслэл, зорилт, хамарсан хүрээ, арга зүй, шалгуур үзүүлэлтүүд, 1."Сэлэнгэ барилга захиалагч" ОНӨААТҮГ-ын үйл ажиллагаа нь холбогдох хууль, эрхийн актын хүрээнд, үр нөлөөтэй хэрэгжиж байна уу.
Тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа	- <i>Үйл ажиллагаа нь холбогдох хууль эрхийн актын хүрээнд үр нөлөөтэй хэрэгжиж байна уу</i> - <i>Үйл ажиллагааны төлөвлөгөө, үр дүнгийн тайланг ТУЗ болон холбогдох бусад байгууллагаар хэлэлцэж үнэлэлт, дүгнэлт өгөгдөж байна уу.</i> - <i>Үндсэн болон санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналт хийгдэж байна уу.</i>
Аудитын менежер Б.Батмөнх	2. "Сэлэнгэ барилга захиалагч" ОНӨААТҮГ нь орлого, зарлагаа үндэслэлтэй төлөвлөж, үр ашигтай ажиллаж байна уу. - <i>Үйл ажиллагааны орлогыг бүрэн дүүрэн, үндэслэлтэй төлөвлөн төвлөрүүлж байна уу.</i> - <i>Төвлөрсөн орлогыг үр ашигтай, арвилан хэмнэлттэй зарцуулж байна уу</i> - <i>Авлага, өглөгийг барагдуулж, үр ашигтай ажиллаж байгаа эсэх.</i>
Ахлах аудитор Б.Наранчимэг	3.Хөрөнгийн худалдан авалт, ашиглалт, зарцуулалт арвилан хэмнэлт, үр ашигтай байна уу. -<i>Худалдан авах ажиллагааг холбогдох хууль, эрхийн актын хүрээнд зохион байгуулж байна уу</i> - <i>Хөрөнгө нөөцийг хэрэгцээ, шаардлагын хэмжээнд бэлтгэн, ашиглаж байна уу</i> - <i>Хөрөнгийг бүртгэл тооцоонд бүрэн тусгаж, тооллого, тооцоог цаг хугацаанд нь гүйцэтгэж байна уу.</i>
2016 оны 04 сар	
Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70362442 дугаарын утас, 70363040 дугаарын факсаар харилцана уу.	
ХАЯГ:Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сум аймгийн ЗДТГ-ын байрны Өргөтгөлд	Илрүүлсэн зөрчил Аудитын дүгнэлт Зөвлөмж

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

МУ	Монгол улс
УИХ	Улсын Их Хурал
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ҮАГ	Үндэсний аудитын газар
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТБОНӨХБАҮХА	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах
ГХБХБГ	Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар
ХБХ	Хөгжлийн бодлогын хэлтэс
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
УТХО	Улсын төсвийн хөрөнгө оруулалт
НББ	Нягтлан бодох бүртгэл
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл
СТСХ	Санхүү Төрийн Сангийн Хэлтэс
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ХАА	Худалдан авах ажиллагаа

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ

Аудит хийх бүрэн эрх, үндэслэл

Аудитыг Сэлэнгэ аймгийн Аудитын газрын 2016 оны бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

Аудитын зорилт

“Цагааннуур тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГ-ын үйл ажиллагааны үр дүнд аудит хийж дүнг албан тушаалтнуудад танилцуулах, олон нийтэд мэдээлэхэд гүйцэтгэлийн аудитын зорилт оршлоо. Уг зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд гүйцэтгэв. Үүнд:

1. “Цагааннуур тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГ-ын үйл ажиллагаа нь холбогдох хууль, эрхийн актын хүрээнд, үр нөлөөтэй хэрэгжиж байна уу.
 - *Үйл ажиллагаа нь холбогдох хууль эрхийн актын хүрээнд үр нөлөөтэй хэрэгжиж байна уу*
 - *Үйл ажиллагааны төлөвлөгөө, үр дүнгийн тайланг ТУЗ болон холбогдох бусад байгууллагаар хэлэлцэж үнэлэлт, дүгнэлт өгөгдөж байна уу.*
 - *Үндсэн болон санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналт хийгдэж байна уу.*
2. “Цагааннуур тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГ нь орлого, зарлагаа үндэслэлтэй төлөвлөж, үр ашигтай ажиллаж байна уу.
 - *Үйл ажиллагааны орлогыг бүрэн дүүрэн, үндэслэлтэй төлөвлөн төвлөрүүлж байна уу.*
 - *Төвлөрсөн орлогыг үр ашигтай, арвилан хэмнэлттэй зарцуулж байна уу*
 - *Авлага, өглөгийг барагдуулж, үр ашигтай ажиллаж байгаа эсэх.*
3. Хөрөнгийн худалдан авалт, ашиглалт, зарцуулалт арвилан хэмнэлт, үр ашигтай байна уу.
 - *Худалдан авах ажиллагааг холбогдох хууль, эрхийн актын хүрээнд зохион байгуулж байна уу*
 - *Хөрөнгө нөөцийг хэрэгцээ, шаардлагын хэмжээнд бэлтгэн, ашиглаж байна уу*
 - *Хөрөнгийг бүртгэл тооцоонд бүрэн тусгаж, тооллого, тооцоог цаг хугацаанд нь гүйцэтгэж байна уу.*

Хамарсан хүрээ

Аудитаар тус ОНӨААТҮГ-ын 2015, 2016 оны эхний улирлын байдлаар хэрэгжүүлсэн ажил үйлчилгээ, орлогын бүрдүүлэлт, хөрөнгийн зарцуулалтыг хамарч шалгав.

Арга зүй

Аудитыг гүйцэтгэхэд Төрийн хяналт шалгалтын стандарт, түүнийг хэрэгжүүлэх аргачилсан зөвлөмж, Гүйцэтгэлийн аудитын удирдамж / АДБОУС-3000-3001/-ийн дагуу аудитын тайлангийн дүн дүгнэлтэд дэмжлэг болох нотлох зүйлс, холбогдох мэдээ судалгаанд тулгуурлан аудитыг хийж гүйцэтгэв.

Ашигласан хууль тогтоомж, шалгуур үзүүлэлт

МУ-ын Төсвийн тухай хууль, Иргэний тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Усны тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, ТБОНӨХБАҮХА тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулиуд болон эдгээр хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан гаргасан УИХ, Засгийн газрын тогтоол, бусад эрхийн актууд, Сангийн сайдын 2012 оны 290 дүгээр тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтын журам”, Сангийн сайдын 2012 оны 264 дүгээр тушаалаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ, худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2013 оны 104 дүгээр тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн харилцааг зохицуулах журам”, Цагааннуур сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2013 оны 05 дүгээр тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын дүрэм” болон холбогдох бусад хууль тогтоомж, эрхийн актуудыг шалгуур үзүүлэлт болгон ашиглав.

Аудит хийх бүрэлдэхүүн, хугацаа

Аудитыг Сэлэнгэ аймгийн Аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа удирдаж, аудитын менежер Б.Батмөнх явцын болон чанарын хяналтыг гүйцэтгэн, ахлах аудитор Б.Наранчимэг 2016 оны 06 дугаар сарын 10-наас 07 дугаар сарын 18-ны хооронд хийж гүйцэтгэлээ.

АУДИТЫН ДҮН

Бүлэг 1. “Цагааннуур тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГ-ын үйл ажиллагаа нь холбогдох хууль эрхийн актын хүрээнд үр нөлөөтэй хэрэгжиж байна уу?

А.1.”Цагааннуур тохижилт үйлчилгээ”ОНӨААТҮГ-ын дүрэмд орлогын эх үүсвэрийг тусгаагүй байна.

1.1. МУ-ын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн холбогдох заалтыг үндэслэн Цагааннуур сумын ИТХТ-ийн 2013 оны 05-р сарын 06-ны өдрийн 16 дугаар тогтоолоор “*орон нутгийн өмчийн нийтийн эзэмшлийн зам талбай, гэрэлтүүлэг, сумын усан сан, цэвэр усны шугамын ашиглалт, хамгаалалт, засвар үйлчилгээг хариуцан ажиллах*” зорилго бүхий сумын Засаг даргын дэргэдэх “Цагааннуур тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГ-ыг байгуулж үйлдвэрийн газрын дүрмийг баталсан байна.

1.2. Үйлдвэрийн газрын даргаар анх З.Гомбожавыг томилсон бол Цагааннуур сумын засаг даргын 2015 оны 06-р сарын 04-ны өдрийн Б/07 тоот захирамжаар Ц.Эрдэнэчулууныг томилж хөдөлмөрийн гэрээ байгуулсан байна.

1.3. Үйлдвэрийн газрын дүрмийн 1.1-д “...*өөрийгөө санхүүжүүлэх зорилгоор ажиллах орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар...*” гэж тодорхойлсон боловч өөрийгөө санхүүжүүлэх орлогын эх үүсвэрийг тодорхой зааж өгөөгүй нь МУ-ын Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 2¹-дэх заалттай нийцэхгүй байна.

А.2.Үйл ажиллагаа нь төлөвлөгдөөгүй, урсгалаар явагдаж ирсэн байна.

1.4. “Цагааннуур тохижилт үйлчигээ” ОНӨААТҮГ- нь орлогоороо зарлагаа нөхөж ашигтай ажиллах талаар бодлого, хэтийн болон ойрын төлөвлөгөө боловсруулаагүй, үйл ажиллагааны төлөвлөгөө хийж холбогдох байгууллагаар хянуулж батлуулаагүй, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20-р зүйлийн 3² дах заалтын дагуу эрх үүргээ хэрэгжүүлээгүй байна.

1.5. Цагааннуур сумын ИТХ үйлдвэрийн газрыг байгуулсан тогтоол гаргаж, дүрмийг баталснаас өөрөөр үйл ажиллагааны төлөвлөгөөг хийлгэх талаар шаардаагүй, үйл ажиллагааны үр дүнг үнэлээгүй, цаашдын зорилтыг тодорхойлж дүгнэлт чиглэл өгөөгүй байна.

1.6. Анх байгуулагдснаас хойш 2013-2014 онуудад санхүүгийн тайлан баланс гаргаагүй, үйл ажиллагааны үр дүн ашиг, алдагдлыг тооцоогүй, зөвхөн төсвийн байгууллагуудын усны төлбөрийг төвлөрүүлэн цөөхөн хэдэн хүн цалинжуулах, ЗДТГ-ын аж ахуйн зарим үйл ажиллагааг зохион байгуулах зэрэгт хөрөнгө нөөцийг зарцуулж иржээ.

1.7. Тайлант 2015 онд 1652.6 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Цаашид ч үйл ажиллагааны орлогыг тодорхой болгож нэмэгдүүлэхгүй болон менежментийн өөрчлөлт хийгээгүй тохиолдолд алдагдалтай ажиллаж, оршин тогтнох боломжгүй болох эрсдэл үүсэж байгаа нь МУ-ын Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 15-р зүйлийн 2 дах “*Өөрт олгогдсон эд хөрөнгийн үндсэн дээр өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар бие даан иргэний гүйлгээнд ордог хуулийн этгээдийг аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар гэнэ*” гэсэн заалтыг зөрчихөд хүргэж байна. Энэ нь цаашид уг аж ахуйн нэгж оршин тогтнох чадамж байгаа эсэхэд дүн шинжилгээ хийх, удирдлага, зохион байгуулалт, менежментийн өөрчлөлт зайлшгүй шаардлагатай болохыг харуулж байна.

А.3.Үндсэн болон санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт огт хийгдээгүй байна.

¹ Өөрт олгогдсон эд хөрөнгийн үндсэн дээр өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар ажиллаж бие даан иргэний гүйлгээнд ордог хуулийн этгээдийг аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар гэнэ”

² Үйлдвэрийн газрын үйлдвэрлэл санхүүгийн төлөвлөгөө боловсруулж зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах

1.8. Сумын ИТХТ болон Засаг дарга МУ-ын Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 2³ -д заасан бүрэн эрхээ хэрэгжүүлээгүйгээс тус үйлдвэрийн газрын үндсэн болон санхүүгийн үйл ажиллагаанд хяналт огт тавиагүй, зөвхөн газрын дүрмийг баталж, даргыг томилсноор үйл ажиллагаагаа хязгаарлажээ.

1.9. Орон нутгийн мэдлийн өмч хөрөнгийг ашиглаж орлого олж байгаа учраас сумын ИТХ болон Засаг даргын зүгээс өмч хөрөнгийн ашиглалт зарцуулалтанд хяналт тавих хэрэгтэй байна.

Бүлэг 2. “Цагааннуур тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГ нь орлого, зарлагаа үндэслэлтэй төлөвлөж, үр ашигтай ажиллаж байна уу.

Б.1.Орлогыг төлөвлөөгүйгээс иргэд, аж ахуйн нэгжийн хэрэглэсэн усны төлбөрийг бүрэн төвлөрүүлээгүй байна.

2.1. Аудитын тайлангийн 1-р бүлэгт дурдсанчлан үйл ажиллагааны орлого, зарлагыг тооцож төлөвлөгөө боловсруулаагүй байна. Тус байгууллагын орлогын бүрдүүлэлт, эх үүсвэр нь дан ганц төсөвт байгууллагуудын цэвэр усны төлбөрөөс бүрдэж байна.

2.2. Тайлант 2015 онд төсөвт газруудаас 27469.8 мянган төгрөг, иргэдээс 165.0 мянган төгрөгийн цэвэр усны төлбөр, 3000.0 мянган төгрөгийн түрээсийн төлбөр нийт 30634.8 мянган төгрөг, 2016 оны 1-р улирлын байдлаар 8043.7 мянган төгрөгийн орлого бүрдүүлжээ.

2.3. Цагааннуур сум нь аймгийн хэмжээнд хүн ам ихтэй, томоохон сум суурин боловч хүн амын ундны болон ахуйн хэрэглээний усны хэрэгцээг тооцон орлогын төлөвлөлтийг хийх боломжийг ашиглаагүй байна.

2.4. “Цагааннуур тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГ нь суманд үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, компаниудтай цэвэр усаар хангах гэрээ хийсэн боловч Атар трейд ХХК-иас бусад иргэн, компаниуд усны төлбөрөө огт хийгээгүй байна. Сумын хэмжээнд цэвэр ус түгээдэг 4 худаг ажилладаг боловч олсон орлогыг үйлдвэрийн газар төвлөрүүлэхгүйгээр ус түгээгч авч иржээ.

Үйлдвэрийн газрын дүрэмд зааснаар сумын төвийн худаг, усан сангийн засвар үйлчилгээг хариуцаж багагүй хөрөнгө зарцуулж байгаа боловч орлогыг үйлдвэрийн газарт төвлөрүүлэхгүй байгаа нь МУ-ын Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 15-р зүйлийн 2-д заасан өөрт олгогдсон эд хөрөнгийн үндсэн дээр өөрийгөө санхүүжүүлэх зарчимд нийцэхгүй байна.

2.5. Цэвэр усаар хангахаар байгуулсан гэрээний дагуу сард багаар тооцоход аж ахуйн нэгжүүдээс 500.0-1000.0 мянган төгрөг, сумын 4000 иргэн өдөрт хамгийн багаар 5⁴ л ус хэрэглэнэ гэж үзвэл жилд 14600.0 мянган төгрөгийн орлого олох боломж байна. Мөн 16 айл цэвэр усны шугам татаж хэрэглээний усны төлбөрт 4-р

³ Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчид, Засаг даргаас орон нутгийн өмчийн хөрөнгийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах, эрхээ хэрэгжүүлэх талаар зохиосон ажил үр ашгийн тайлан, нэгдсэн тооллогын дүнг жил бүр хэлэлцэж дүгнэлт чиглэл өгөх

⁴ Сумын ИТХТ-ийн 2010 оны 05-р сарын 18-ны өдрийн 16 дугаар тогтоолоор усны үнийг тогтоосон.

сарын 01-нээс 10-р сарын 01 хүртэл хугацаанд сард 15.0 мянган төгрөг төлөхөөр гэрээ хийсэн бөгөөд гэрээний дагуу тооцоход 1680.0 мянган төгрөгийн орлого олох боломжтой боловч ердөө 165.0 мянган төгрөгийн л орлого төвлөрүүлсэн байна.

Б.2.Үйл ажиллагааны зардлыг төлөвлөөгүйгээс үргүй зардал гаргасан байна.

2.6.Тайлант 2015 онд 32287.4 мянган төгрөгийн, 2016 оны эхний улирлын байдлаар 6903.4 мянган төгрөгийн зардал гарган ажилласан байна.

2.7.Тайлант оны нийт зардлын 54.3 хувийг буюу 16116.5 мянган төгрөг цалин шимтгэлд, 23.3 хувийг буюу 6915.1 мянган төгрөг цахилгаанд, 4.5 хувийг буюу 1327.2 мянган төгрөг шатахуунд, 11.6 хувийг буюу 3102.3 мянган төгрөг сэлбэг материалд, 6.3 хувийг бусад зүйлд зарцуулсан байна.

2.8.Үйл ажиллагааны төлөвлөгөө хийгээгүйгээс хөрөнгө нөөцийг олсны хэмжээгээр үр ашиг муутай зарцуулсан байна. Тухайлбал ЗДТГ-ын мэдлийн зочид буудлын тохижилтонд 1200.0 мянган төгрөг, баяр наадмаар 631.0 мянган төгрөг, хүнсний материалд 875.3 мянган төгрөг, зөөврийн компьютер худалдан авахад 1000.0 мянган төгрөгийг зарцуулжээ.

Өөрөөр хэлбэл, үйлдвэрийн газрын дүрэмд заасан үйл ажиллагааны чиглэлд хамааралгүй ажил үйлчилгээг эрхэлж хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан байна.

2.9.2016 оны 3-р сард дарга Ц.Эрдэнэчулуун зөөврийн компьютер худалдан авахаар 1000.0 мянган төгрөг бэлнээр авсан боловч уг компьютерийг бэлтгэн нийлүүлээгүй байв.

2.10. “Цагааннуур тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГ нь усан санг ажиллуулах, засвар үйлчилгээ хийх зэрэгт 10017.4 мянган төгрөг зарцуулсан боловч иргэд аж ахуйн нэгжээс усны төлбөр нэхэмжилж аваагүй, алдагдал хүлээж байгааг таслан зогсоож төрийн мэдлийн өмч хөрөнгө ашиглан орлого олж байгаа учраас хэрэглэгчдээс зохих хэмжээний төлбөр авч орлогоороо зарлагаа нөхөж ажиллах, ажиллагсдыг тогтмолоор бус орлогын хувь хэмжээгээр цалинжуулах зэргээр зохион байгуулалтын өөрчлөлт хийх нь зүйтэй юм.

Б.3.Авлага өглөгийг огт бүртгээгүй байна.

2.11.Анх байгуулагдсан цагаас эхлэн сумын цэвэр усны хэрэгцээг бүрэн хангаж ирсэн боловч нэг ч байгууллага иргэдээс усны үнэ нэхэмжилж данс бүртгэлд тусгаагүй байна.

2.12.Иргэн аж ахуйн нэгжүүдтэй цэвэр ус хангах гэрээний усны төлбөр нэхэмжилж аваагүй боловч авлагаар бүртгээгүй байна.

Илрүүлсэн зөрчил

Аудитын явцад дараах зөрчлүүд илэрлээ.Үүнд:

1. Зөөврийн компьютер худалдан авахаар бэлнээр гаргасан боловч бэлтгэн нийлүүлээгүй 1000.0 мянган төгрөгийг нөхөн төлүүлэх акт тогтоов.

Дүгнэлт

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна. Үүнд:

- Үйл ажиллагааны чиглэл, үр дүн нь тодорхойгүй байна.
- Үйл ажиллагааны орлого нь тодорхой бус бөгөөд орлогоо бүрэн төвлөрүүлж чадахгүй байна.
- Үйл ажиллагааны төлөвлөгөө хийж батлуулж мөрдөөгүйгээс зөвхөн төсөвт газруудын усны төлбөрийг түшиглэн үйл ажиллагаагаа явуулж байна.
- “Цагааннуур тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГ-ыг үүсгэн байгуулагч сумын ИТХ, Засаг даргын зүгээс үйл ажиллагаанд нь хяналт тавьж, үр дүнг үнэлээгүй байна.
- Хэрэглэгчдээс усны орлогыг бүрэн тооцож нэхэмжлээгүй, авлага үүсгэж бүртгээгүй байна.
- Үүсгэн байгуулагдснаас хойш 2 жил дараалан санхүүгийн тайлан гаргаагүй байна.

Зөвлөмж

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтнуудад зөвлөж байна. Үүнд:

Сумын ИТХ-ын дарга болон, Засаг дарга нарт:

- “Цагааннуур тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГ-ын үйл ажиллагаанд хяналт тавьж үр дүнг үнэлж байх, цаашид оршин тогтнох боломж бий эсэхийг судалж, шийдвэр гаргах.
- Зайлшгүй оршин тогтнох шаардлагатай бол удирдлага, зохион байгуулалт, менежментийг өөрчилж, өөрөө өөрийгөө санхүүжүүлж ажиллах нөхцөл боломжийг судалж хэрэгжүүлэх.
- Сумын төвийн айл өрх, албан газруудыг дулаанаар хангадаг аж ахуйн нэгж цэвэр, бохир усны асуудлыг хамт шийдвэрлэдэг бусад сумдын жишгийг хэрэгжүүлэх боломж нөхцлийг судлах.

Цагааннуур тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГ-ын дарга-д:

- Хэрэглэгчдээс цэвэр усны төлбөрийг бүрэн нэхэмжилж авах, авлага үүсгэж барагдуулах.
- Худгийн ус түгээгчидтэй гэрээ байгуулж тодорхой хувийг үйлдвэрийн газарт оруулах нөхцөл боломжийг судалж хэрэгжүүлэх.
- Төсөвт байгууллагуудаас бусад хэрэглэгчийн хэрэглээний орлогыг бүрэн төвлөрүүлэх.
- Орлогоороо зарлагаа нөхөж, өөрөө өөрийгөө санхүүжүүлж ажиллах нөхцлийг бүрдүүлэх.
- Санхүүгийн тайланг хуулийн хугацаанд гаргаж, холбогдох байгууллагад хүргүүлэх.

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

АХЛАХ АУДИТОР

Ч.ЭНХТУЯА

Б.БАТМӨНХ

Б.НАРАНЧИМЭГ

